

МОНГОЛЫН ГҮН УХААНЫ УЛАМЖЛАЛ XIII ЗУУНД

С.Дашцэвэл (Ph.D)

Төв Азийн тал нутагт манай эриний өмнөх хэдэн зуунаас төр улс байгуулалцаж, хоёр мянга их гаруй жилийн түүхийг бүтээсэн монголчуудын хувьд гүн ухааны уламжлал бас л эрт үеэс эхлэлтэй юм. Учир нь Төв Азийн нүүдэлчид эртний Энэтхэг болон дорно дахины соёл иргэншлийн үр шимийг авах боломж их байжээ. Тэд Төв Азийн өргөн уудам тал нутагт нүүдэллэн, бусад суурин соёлын улсуудтай дайтаж, найрамдаж ахуйдаа бусдын соёл иргэншил (цивилизация), түүний дотор ертөнцийг үзэх үзэл, гүн ухааны сэтгэлгээнээс суралцаж байсан нь лавтай.

Монголчуудын анхны гүн ухааны сэтгэлгээ бөөгийн мөргөл (шаманизм)-тэй холбоотой байв. Монголчууд байгаль цаг уур, аж төрөх хэв ёс зэрэг Бөөгийн мөргөл нь газар тэнгэр, гал усыг тусгай эзэнтэй хэмээн шүтэх шүтлэг бөгөөд монголчууд яваандаа тэнгэрийг онцгойлон шүтэж, хамгийг захиран зохицуулагч ер бусын эрхэм дээд зүйл хэмээн үзэх болж тэр үзэл нь Хүннү гүрний үеэс улбаалж Монголын эзэнт гүрэн үүсч хүчирхэгжих явцад улам боловсронгуй болж Төв Азийн монголчууд, бусад эсгийн туургатан нүүдэлчдийн ертөнцийг үзэх гол нэгэн итгэл үнэмшил буюу (Будда, Лал, Христос мэт дэлхий нийтийн шинжтэй шашин биш ч) бүс нутгийн шинжтэй нэгэн төрөл шашны байдалтай болсон мэт байдаг. Энэ хир миний бие Хүннү-гийн үеийн баримтыг биш сүүлийн үеийн гарын доорхи баримт түшин бичсэн учир Хүннү-ийн үед бөө мөргөл шашны хэмжээнд хүрч хөгжсөнийг хараахан нуталж чадахгүй, гагцхүү эзэнт гүрний үеийн бөөгийн шашны байдлыг товч дурдав.

Дэлхийд тэнгэрийг шүтдэггүй байсан ард түмэн үгүй гэж хэлж болно. Гэвч Монголчуудын хувьд Мөнх тэнгэр нь ахуй ертөнцийг үүсгэгч төдийгүй ертөнцийн алив зүйлийг зохицуулагч хамгийн дээд эзэн гэж эрт үеэс төсөөлөгдөж байв. Үүнийг Нууц товчоо зэрэг сурвалжуудаас төвөггүй харж болно. Монголын нэгдсэн төр улс XIII зууны эхэнд байгуулагдмагц дээр өгүүлсэн итгэл үнэмшил нь засаг төрийн эрх ашигт үйлчлэх гүн ухааны нэлээд нарийн тогтолцоо бүхий үзэл сэтгэлгээ болж төлөвшсөн бололтой. Тухайлбал XIII зууны үеэс уламжилж ирсэн тамгын бичиг, пайз зэрэг нь “Мөнх тэнгэрийн хүчин дор” гэсэн үгээр эхэлдэг нь засаг төрийн эрх хүчийг дээд тэнгэрээс зарлигтай болгон үзүүлэх гэсэн санаа юм. Ийм санаа Төв Азид бүрт эрт үед ч байсан. Тэгээд ч хагацсан улсыг хамтатган, хамаг монголыг нэгтгэх нь тэнгэрийн таалалд нийцсэн, бараг л тэнгэрийн зарлиг гэж Чингис хаан үзэж энэ үйлсийг хэрэгжүүлж боджуулахад тэнгэр эзэн туслах ёстой гэж бат итгэж байв.

Их Монгол Улс хүчирхэгжин дэлхийн олон газар орныг эрхшээл нөлөөндөө оруулах тусам уг үзэл, сэтгэлгээний итгэл үнэмшил улам

*. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

бэхжиж түүний бодит ач холбогдол ч ихсч ирсэн бололтой. Нөгөө талаар Уйгур, Түрэг, Төвд, Энэтхэг зэрэг газар орны бурханы болон нестор шашны гүн ухааны нөлөө нэвтрэх боломж улам өргөжсөн байна. Монголчууд болон Төв Азийн нүүдэлчид эрт дээр үеэс хэрэглэж ирсэн “Хөх тэнгэр” хэмээх үг эртний энэтхэгийн махбодийн онолтой холбоотой хэмээн зарим эрдэмтэд үзэж байна. (Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг 1991 он № 3, 111-р тал). Эртний Энэтхэг, Түрэг, Уйгур, Төвдөөр дамжин Монголд орж ирсэн “мандал”, “махбодийн” онолоор бол ертөнцийг буй болгогч хий, гал, ус, шороо хэмээх 4 язгуур махбодь байх бөгөөд түүнийг хар, шар, улаан, цагаан өнгөөр төлөөлүүлж байв. Эдгээр 4 махбодийн хөдлөх орон зай нь болох огторгуй мандал нь хөх өнгөтэй бөгөөд хөх өнгө нь махбодийг төлөөлсөн бүх өнгийн дэвсгэр буюу дөрвүүлэнд нь оролцсон ерөнхий өнгө болдог учир Монгол улсыг 4 махбодийн хөдөлж хөгжих орон зай нь болсон огторгуй ба хөх өнгөөр төлөөлүүлж байжээ. Ийнхүү хөх тэнгэр, хөх монгол хэмээх хэллэг хоорондоо утга агуулгын гүн холбоотой болж XIII зуунд улам өргөн хэрэглэгдэх болжээ. Чингис хаан Хятадын Чанчун бомбод (хятадын бомбын шашны санваартан) илгээсэн захидалдаа “Таван өнгө, дөрвөн харь улс” зэрэг үгийг анх дурсан байдгаас гадна XIII-XIV зууны зааг дээр бичигдсэн “Арван буянт номын цагаан түүх” номонд “Таван өнгө дөрвөн харь Их улс дагаан ийн зарлиг болов” гэж бичсэн байна. Хожмын монгол сурвалжуудад “Чингис хаан таван өнгө дөрвөн харийн Их улсыг эрх дороон оруулагсан” гэж олонтаа бичсэн байдаг. Тэр таван өнгийн улс нь Цагаан Солонгос, хар Төвд улаан Хятад, шар Сартуул, Хөх Монгол билээ. Дөрвөн харь улс гэдэг нь Хөх Монголоос бусад дөрөв нь ажээ.

Эзэнт гүрний үеийн монголчуудын гүн ухааны сэтгэлгээн дэх тэнгэрийг шүтэх үзэл нь ийнхүү махбодын онолтой холбогдож өөрийгөө огторгуй буюу хөх өнгөтэй холбосон нь утгаа Хөх Монгол нь бусад өнгийн улсуудыг ерөнхийлөн нэгтгэж захирсан эзэн улс байх ёстой хэмээх үзлийг гүн ухааны үндэстэй болгох гэсэн оролдлого байв. Чингисийн эзэнт гүрний үед энэ нь үлэмж боловсронгуй цэгцтэй үзэл байсан учир түүний итгэл үнэмшил нийгэмд хүчтэй нөлөөлжээ.

Чингисийн эзэнт гүрний үед харийн олон шашны төлөөлөгчдийг эрх тэгш хүндэтгэн хүлээн авч, тэдний үзэл бодол, гүн ухааны сэтгэлгээг ялгаварлан гадуурхалгүй түүнд хүндэтгэлтэй ханддаг байсан нь юуны өмнө бусад бүх шашин суртахуун дээд эзэн тэнгэрийн ивээл дор байх учир түүнийг хүндэтгэх ёстой гэсэн энгийн логик ноёрхож байсанд орших бөгөөд энэ явдал Эзэнт гүрний тэнгэрийн үзэл, түүний улс төр, гүн ухааны сэтгэлгээг баяжуулхад сүрхий нөлөөлжээ.

Гэхдээ нэгэн үе Чингисийн төрийн гол үзэл суртал байсан тэр шашин суртахуун төдийлөн удаан ноёрхсонгүй. Аажимдаа Эзэнт гүрний

хүчин мөхөсдөх явцад бурханы шашинд шахагдан ялангуяа феодалын бутралын үед улам хүчээ алдан суларч дахин бөө мөргөлийнхөө түвшинд бууж олон тэнгэр нарын тухай үзэл ойлголт хөгжиж эхэлсэн бололтой. Энэ үед Монгол орон эдийн засаг, улс төрийн нэгдэлгүй болж өөр хоорондоо удтал дайн дажин хийсэн нь ард олны санаа сэтгэлийг ихэд унагаж цөхөрлийн байдалд оруулжээ. Нөгөө талаар бурханы шашин монголын язгууртнуудын дунд нэлээд эртнээс танил болж улмаар Хуилай хааны үеэс төрийн шашны хэмжээнд хүрсэн нь Тэнгэрийн шүтлэг аажмаар шахагдан байраа тавьж өгөх нэг шалтгаан болжээ. Бурханы шашин нь монголчуудын тэнгэрийг шүтэх шашныг бодвол олон зууны турш боловсорсон оюуны томоохон ололт байснаас түүний нөлөө, үнэмшүүлэх чадвар хүчтэй байсан нь мэдээж. Нөгөө талаар монголчуудын нийгмийн сэтгэлгээ тэр үед дайн дажингүй амар түвшин байх, гаслан зовлонгоос ангижруулах аварлын эзнийг хайж байв. Мөн улс орны тархай бутархай байдлыг нэгдсэн нэг шашны хүчээр гэтлэн давахыг зарим сурвалжит язгууртнууд оролдож эхэлжээ. Энэ бүхний дүнд төвдийн бурханы шашин монголд дэлгэрэх нийгмийн хөрс нэгэнт бүрэлдсэн байв. Зарим судлаачид бурханы шашныг монголд манж нар хүчээр дэлгэрүүлсэн мэт үздэг нь үнэмшил багатайг академич Н.Ишжамц, Ш.Бира нар тэмдэглэсэн байдаг нь үүнтэй холбоотой болов уу. Монголд бурханы шашин (Зонховын шашин буюу шарын шашин) 16,17-р зуунаас хүчтэй дэлгэрэх үед түүнийг дагаад Энэтхэг, Төвдийн оюуны соёлын асар их ололт нэвтэрч монголчуудад гүн ухаан, урлаг соёлын сэргэн мандлыг авчирав. Хэдийгээр тэр үед Монгол нь Манж чин улсын дагуу хартаа орон байсан ч оюуны соёлын хувьд ахиц дэвшлийг олж, ялангуяа гүн ухааны сэтгэлгээ өндөр шатанд хүрч Энэтхэг, Төвдийн гүн ухаантнуудын бичиж туурвисан өдий төдий ном бүтээлийг орчуулж, тайлбарлаж, цааш гүнзгийрүүлж хөгжүүлсэн билээ.

Ашигласан ном

1. Арван буянт номын цагаан түүх. Өвөр монголын хэвлэлийн хороо, 1981 он, 76-р тал.
2. Нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ. 1990 он
3. Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. Хөх хот, 1991 он.
4. Ч.Далай. Монголын бөө мөргөлийн товч түүх. УБ. 1959.
5. Ш.Бира. Монголын түүх соёл, түүх бичлэгийн судалгаа. Токио. 1994 он.
6. С.Дулам. Монгол домог зүйн дүр. УБ. 1989.
7. И.С.Урбанаева. Монгольский мир: человеческое лицо истории. Улан-Удэ, 1992 г.
8. О.Пүрэв. Монгол бөөгийн шашин. УБ. 1998.